

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын
2022 оны 10 дугаар сарын үйл ажиллагааны тайлан

2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

10 дугаар сард 91 албан бичиг бүртгэгдсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 14 ирсэн бөгөөд холбогдох албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг ханган ажиллаж байна. Удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж – 126 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

2022 оны 05 сарын 01-ээс “Цахим гарын үсгийн тухай” хууль хэрэгжиж эхэлснээс хойш 16-аас дээш насны 630 иргэнд тоон гарын үсэг олгосон байна. Цахим гарын үсгийн ач холбогдлын талаар иргэдэд мэдээ мэдээлэл өгч ажиллав.

09 сард 16,25,45 нас хүрсэн 11 иргэнтэй утсаар холбогдон хуулийн хугацаанд иргэний үнэмлэхний бүртгэлд хамруулсан.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр

Төрсний бүртгэл -23 /эр- 15/

Иргэний овог, эцэг эхийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл – 1 / эр – 1/

Нас барсны бүртгэл -10 /эр-9/

Гэрлэсний бүртгэл -3

Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-1

Иргэний үнэмлэх 16 - 14 /эр-6/

Иргэний үнэмлэхний сунгалт 25,45 – 46 /эр-19/

Шилжилт хөдөлгөөн

Баг хороо хоорондын -1

Сум, дүүрэг хоорондын – 14

Нийслэл, аймаг хоорондын -15

Нийт шилжин ирсэн – насанд хүрэгч 30 /эр-16/, насанд хүрээгүй хүүхэд-26

Гэрчилгээ, лавлагаа олголт

Төрсний гэрчилгээ -3

Лавлагаа - 63

Төсөв санхүүгийн талаар

Орон нутгийн төсвийн байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 3-р улирлын санхүүгийн тайланг хүлээн авч Э тайланг шивж нэгтгэн илгээсэн. Мөн ААНБ болон төсвийн байгууллагын татварын нэгдсэн 3-р улирлын тайланг хүлээн авч илгээлээ.

Аймгийн санхүү аудитын хяналт ирж Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2020-2021 оны үйл ажиллагааны санхүүгийн баримтанд хяналт шалгалт хийж шалгалтаар гарсан зөрчил дутагдалыг арилгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдлээ. Орон нутгийн татварын орлого нэр төрлөөр авч үзвэл Малд ноогдох орлого 40 хувийн биелэлтэй, газрын төлбөр 42,0 сая төгрөгөөр, бусад орлого 60,0 сая төгрөгөөр тасраад байна. Үүнд хамтран ажиллах гэрээний дагуу уул уурхайн компаниас орох ёстой мөнгө орохгүй байгаатай холбоотой. Орон нутгийн орлогод 9 шонхор шувууны 288,0 сая төгрөгийн орлого ороод байна.

Хөрөнгө оруулалт- ОНХС-ийн 2022 оны гүйцэтгэл

	Төсөл, арга хэмжээний нэр	төл	гүйц	Гүйцэтгэгч байгууллага
1	Мал угаалын ванн	15000,0	15000,0	Жавхлантын овоо ХХК
2	Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлыг хангах	20000,0	18890,0	Иргэн Э.Нандинцэцэг
3	Гэрэлтүүлэг болон бүтээн байгуулалтын засвар	20000,0	21154,9	Камержуулалт,гэрэлтү үлэг ногоон байгууламжын хашаа
4	ЭМТ-ийн тоног төхөөрөмж	45000,0	43455,0	Мед буян трейд ххк
5	Соёлын төвийн то төхөөрөмж, тайзны хөшиг, гадна хашаа	60000,0	59952,9	Хуралдай тур ххк
6	Нийтийн ахуй үйлчилгээний засвар үйлчилгээ	40231,9	0	Хийгдээгүй
7	Газар чөлөөлөлт	79000,0	44000,0	
8	Бага насны хүүхдийн тоглоомын талбай	50000,0	50000,0	Зотол констракшн ХХК
9	Уурын зуухны цэвэр бохир усны шугамын засвар	20000,0	19980,0	Дөрвөлж ХХК
10	Зураг төсвийн үнэ	11806,7	4600,0	

11	Бэлчээрийн менежмент хадлан тэжээл бэлтгэх уст цэг гаргах	27800,5	10183,5	Ээмэгжүүлэлт, өвс тэжээл бэлтгэсэн
12	Малын үүлдвэр угсааг сайжруулах ангилан ялгалт хийх	10000,0	10000,0	Ханилаг ХХК
13	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх	13000,0	9600,0	1,6 тн оготны хор
14	Ногоон байгууламж нэмэгдүүлэх хамгаалах	60000,0		Зотол констракшин ХХК
15	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	20000,0	20000,0	Ус оюу ХХК
	Нийт дүн	491839,1	326816,3	

ТА-3 төслийн хэрэгжилтэнд Дэлхийн банкнаас ХШҮ-ний ажлынхан ирэхэд ОНХС-ийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд хэрхэн хэрэгжүүлж ажилладаг, иргэдийн оролцоог хэрхэн хангадаг талаар сургалт бэлдэж тависан.

Жилийн эцэс болж байгаатай холбогдуулан өр авлагагүй ажиллах орлогын төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө ажиллаж байна.

Бусад ажлын хүрээнд.

Хүндэтгэлийн өргөөг 380 вт-ын цахилгаан шугаманд холбож халаалтын асуудлыг шийдэж мөн гудамжны гэрэлтүүлгийн засварыг бүрэн хийлгэж асаалтын бүрэн шийдсэн.

Ногоон байгууламжыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хийдэд мод тарьсан. Жишиг хороололын худгын засварт 2,0 сая төгрөгийн гэрээ байгуулж засах. Малын ангилалтын нэгжтэй гэрээ байгуулан 3,7 сая төгрөгөөр ангилан ялгалт хийгдлээ.

Соёлын төвийн тоног төхөөрөмж худалдан авах гэрээ байгуулан аймгаас хөрөнгө оруулалтын мөнгийг татаж авч хийж гүйцтгэлээ.

Татварын чиглэлээр:

2022 оны Малын тооллогын дүнг багаар ялган гаргаж иргэдэд нэхэмжлэлийг хэвлэн татварын төлүүлж төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна. Татварын тайлангын 3-р улирлын НӨАТ, Цалин, Суутганы тайлангын ирцийг 100% хангуулан ажилласан. 2021 оны малын тоо толгойн албан татвар төлөөгүй иргэдийн судалгааг гаргаж багийн Дарга нарт мэдээлэл өгсөн. Авто тээвэр үндэсний төвөөс ирсэн сүүлийн 3 жил авто үзлэгт ороогүй 225 тээврийн хэрэгсэл ирсэн бүртгэлийг хүлээн авч баг тус бүрээр нь ялган гаргаж багийн Засаг дарга нарт хүргүүлсэн.

Байгаль орчны чиглэлээр:

Ногоон байгууламжийн чиглэлээр:

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх, Бүх нийтээр мод тарих өдрүүдийг тохиолдуулан сумын хэмжээнд мод тарих өдрийг 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 13-ныг хүртэлх хугацаанд зохион байгууллаа. 10 сарын 07-ны өдөр болсон “Тарьц суулгац 2022” үзэсгэлэн худалдаанд сумын Засаг даргын Тамгын газрын даргатай хамтран оролцож Байгаль орчны газраас дэмжлэгээр өгсөн 412ш мод болон мод хэлбэржүүлэгч төхөөрөмжийг гардан авч мөн иргэдийн захиалга, сумын төвд тарих шаардлага тарьц суулгацыг худалдан авсан. Уулбаян сум намрын тарилтыг нийт 1324ш мод тариж “Дечинчойхорлин хийд”, жишиг хорооллын хойд талын ногоон байгууламж, иргэд өөрийн эзэмшил газарт гэсэн тарилтыг тус тус хийлээ. Мод тарилтад Засаг даргын Тамгын газар, Сургууль, Эмнэлэг, Цэцэрлэг, Соёлын төв, иргэд хамтран оролцсон. Монос- 118ш, Гүйлс-118ш, Нарс-31ш, Улиас-115, Голтбор-40ш, Тэсмэг-65ш, Агч-30ш, Бургас-100ш, Нохойн хошуу-30ш, Тэхийн шээг-5ш, Хайлаас-672ш тус тус тариж нийтдээ 1324 ширхэг мод үүнээс Б.Эрдэнэхүү ламын хөрөнгө оруулалтаар 812ширхэг мод тарилаа.

Сумын Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгт Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарлуу санал хүргүүлэн 3н хүний бүрэлдэхүүнтэй ирж оролцсон. Тус өдөрлөгөөр Эко клубийн төслийн уралдааны шагналыг гардуулан гэрээ байгуулж, аюултай хог хаягдлыг үүсгэгч байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цагаан зээрийн хээрийн хяналт шалгалтыг зохион байгуулж, мод тарилтад болон ундны усны энгийн хамгаалалтын бүсийг тогтоох самбар гардуулж суурилуулсан ажилд хамтран оролцсон.

Сумын төвийн өнгө үзэмж, аюулгүй байдал, хог хаягдлыг багасгах, иргэдийн амар тайван байдлыг хангуулах зорилгоор золбин нохой устгалын ажлыг 2022 оны 10 дугаар сарын 09-ны өдөр Хэнтий аймгийн анчин Чинбаттай гарээний дагуу зохион байгууллаа. Тус ажлыг өглөөний 07 цагаас 16 цаг хүртэлх хугацаанд 22 нохой устгаж аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хянан шалгаж устгасан нохойг сумын хогийн нэгдсэн төвлөрсөн цэгт асгаж ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан. Тус ажлын зардалд байгаль хамгаалах сангаас 20 литр ДТ, 50 литр А92 шатахуун зарцуулагдсан.

Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос гадаад орчны агаарын бохирдлыг бууруулах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, иргэдэд мэдлэг, мэдээлэл түгээх, амьдралын зөв дадлыг бий болгох зорилгоор Монгол Улсын хэмжээнд “Яндангаа хөөлье-Өнтэй өвөлжье” аяныг зарласан. Энэхүү аяныг хүрээнд галлагааны улирал эхэлү байгаатай холбогдуулж зуух, пийшин, яндангийн битүүмжлэл алдагдах, цэвэрлэгээ хийгээгүйн улмаас бөглөрөл үүсэх, зуухны битүүмжлэл алдагдсан зэргээс шалтгаалан угаар гарах угаарын хийн хордлогод өртөх иргэдийн эрүүл мэнд, амь нас хохирох эрсдэл үүсэх шалтгаануудаас урьдчилан сэргийлж сумын иргэн Мэндсайхан-тай хамтран ажиллах гэрээ байгуулж Засаг даргын тамгын газраас

багаж төхөөрөмжөөр хангаж, яндан хөөлөх гэж буй иргэд ААН байгууллагуудад заавар зөвлөмж өгч ажиллах хүчээр иргэн Мэндсайхан ажиллаа. ЗДТГазраас захиалагчийг холбож өгч 8н иргэн, 1 ААН байгууллага хамрагдаж тус бүр 30.000 төгрөгөөр ажлын хөлсөнд тооцож 270.000 төгрөг хуримтлагдаж үүнээс 160.000 төгрөг Мэндсайхан-д ажлын хөлс, 110.000 төгрөг ЗДТГазар-т төвлөрсөн. Мөн 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр болох “Нээлттэй Хаалганы өдөрлөг”-т иргэдэд мэдээлэл сургалт зохион байгуулах, яндан ханан пийшинг хөөлөх заавар зөвлөмж өгсөн.

Ногоон байгууламжийн хашааг сэргээн засварлах ажилд нутгийн иргэн Цэрэнхүүтэй хамтран гагнуурын ажлыг зохион байгуулсан. Урамшуулалд 20.000 төгрөг зарцуулагдсан.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

“Намрын ногоон өдрүүд Сүхбаатарт үйлдвэрлэв-2022” арга хэмжээ 2022 оны 09 дүгээр сарын 28,29-ны өдөр зохион байгуулагдаж. “Шилмэл мал” төрөлд амжилттай оролцож 8 сумын 5 аж ахуй нэгж 15 иргэний 128 бог мал оролцсоноос “Бүдүүн ухна”, “Төлгөн хуц” 3 дугаар байр, эм ямаа тусгай байранд шалгарсан.

Үржлийн малд үзлэг, ангиалалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг, бүрдүүлэх ажлыг Мөнххаан сумын “Баясгалант сүрэг” үржлийн нэгжтэй 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр гэрээ байгуулж, 2022 оны 10 дугаар сарын 12-18-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Үржлийн малд үзлэг, ангиалалт хийх ажлын хүрээнд Сумын хэмжээнд 5 багийн 6 өрхийн 709 эм хонь, 401 эм ямаа, 65 үнээ нийт 1175 хээлтэгч мал, мөн 7 хуц ухнын суурийн 466 хуц, 223 ухна нийт 689 хээлтүүлэгчид үзлэг ангиалалт хийж, ээмэгжүүлсэн.

Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлын хүрээнд 10 дугаар сарын 10-ны өдөр “Шим ХХК”-тай “Бактерийн бэлдмэл нийлүүлэх гэрээ” байгуулан 1,6 тонн хордуулсан будааг 9,600,000 /есөн сая зургаан зуун мянга/-н төгрөгөөр захиалж 10 дугаар сарын 18-ны өдөр хүлээн авсан.

Гол нэрийн бүтээгдэхүүний Үнийн өсөлтийг 9-10 сартай харьцуулан харуулав.



Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгаа 2022 оны 10 сарын 24-ны байдлаар. Хүнсний бүтээгдэхүүний татан авалт хэвийн явагдаж байна.

2022 оны 10 дугаар сарын 24-ны байдлаар. Бензиний үнийг 9 сартай харьцуулахад А-92, А-80, Дизил түлшний үнэ хэвийн байна.

Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлогын ажлын хүрээнд салбарын бодлогын хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, түүнийг хэрхэн эрсдэл багатай даван туулах, туршлага судлах зорилгоор Малчдын зөвлөгөөн- 2022” арга хэмжээ “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдлийн менежментийг боловсронгуй болгох / АДАПТ/ төсөлтэй хамтран 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Баруун-Урт хотод зохион байгуулагдсан. Зөвлөгөөнд 7 малчдын төлөөлөл болон мэргэжилтнүүд оролцсон.

Тогооч нарын Бүсийн аварга шалгаруулах тэмцээн Түмэнцогт суманд 2022 оны 10 сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тэмцээнд Цэцэрлэг, сургууль, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн төлөөлөл 9 тогооч оролцсон. “Орчин үеийн монгол хоолны” төрөлд Сургуулийн тогооч Б.Цэвээнсүрэн 2-р байр эзэлсэн. Мөн Аймгийн Засаг Даргын Баярын Бичгээр Цэцэрлэгийн тогооч Б.Мөнгөнчимэг Залуучуудын холбооны гарын бэлгээр М.Буямаа нар тус тус шагнагдсан.

Хоршоо хөгжүүлэх сан

2022 оны 10 дугаар сарын 24-ны байдлаар зээлийн эргэн төлөлтөөр 17,077,178 төгрөг хоршоо хөгжүүлэх сангийн дансанд эргэн төлөгдсөн байна. Эргэн төлөлтийг 9 сартай харьцуулахад 2.8 %-иар өссөн байна.

Эргэн төлөлт тогтмол хийж буй зээлдэгчид:

- 2020 онд зээл авсан - Б.Цэрэнхүү, А.Отгонхүү,
- 2021 онд зээл авсан- А.Сарантуяа, Г. Нямдорж, Б.Болдбаяр, Б.Дэнсмаа, Б.Мижиддорж, М. Цолмон, З.Дорж,

Эргэн төлөлт хийхгүй байгаа зээлдэгчид:

- 2019 онд зээл авсан - Б.Сэрчмаа, Л.Мөнхнаст
- 2020 онд зээл авсан- Т.Чулуун
- 2013 онд зээл авсан - Г.Зоригт
- 2021 онд зээл авсан- Д.Түмэндэмбэрэл, Ш.Сарангэрэл

2022 оны 06 сарын 03-ны өдрийн ИТХ-н тогтоолоор Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөнд хяналт тавих чиг үүрэг бүхий Хяналтын зөвлөл нь дарга, иргэний төлөөлөлөөс бүрдсэн 5 гишүүнтэй байгуулагдсан.

Хяналтын үр дүнд, нэгдсэн журмаар эргэн төлөлт удаашралтай байгаа иргэнд зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэл гаргасан бөгөөд чиглэлийн дагуу 2022 оны 10 сарын 15-ны өдөр Санхүү хяналтийн аудитор Л.Цэгмид, Б. Цэрэнпагма, Хяналтын зөвлөлийн гишүүн Д.Оюун, Хоршоо хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн Э.Юмжав, нар хамтран зээл авсан иргэдтэй уулзлаа.

Хоршоо хөгжүүлэх сангаас 2013-2021 онд зээл авсан суманд байгаа иргэдтэй уулзаж, тэдний санаа бодлыг сонсож, хийж буй үйл ажиллагаатай танилцаж, цаашид хэрхэн үр дүнтэй ажиллах, зээлийн эргэн төлөлтийг хувиарын дагуу хугацаанд нь төлж барагдуулах мөн хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгчийн мэдээлэл Монгол банкинд шилжиж зээлээ хугацаандаа төлөхгүй удаашралтай бол муу зээлдэгчийн ангилалд орж дахин зээл авах боломжгүй болж байгаа талаар зөвлөмж зөвлөгөөг хүргэн ажилласан

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр төсөл хөтөлбөрт хамрагдсан 7 иргэдийн үлдэгдлийг утсаар баталгаажуулж ажилласан. Мөн тайлан авч аймаг явуулсан. 2 иргэнд 11 сард багтаж эргэн төлөлтөө хийх талаар мэдэгдэл өгсөн.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

1. Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг сард 2 удаа хийж, асаргаа сунгуулах 11 иргэний материалыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнээс шинээр асаргаанд орох хүсэлт өгсөн 5 иргэн байна.
2. Цалинтай аав хөтөлбөрт 1 иргэн
3. Жирэмсэн эхийн тэтгэмжинд 2 иргэн
4. Хүнсний талон авч байгаа 13 өрхөөс 1 өрхийг нь түтгэлзүүлж, одоогоор 12өрх хамрагдаж байна.
5. Ахмадын баярыг тохиолдуулан Төрийн харъяалалтай 254 ахмадыг 100% шивж нийт 2540000 төгрөг олгосон. Хиймэл шүдний хөнгөлөлтөнд 3 ахмад хамрагдсан.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 648447,2 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -555809,5 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 71364,7 мян төг
- ЭМДаатгалын шимтгэл -21273,0 мян төг орлоо.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох-25 тэтгэврээ өөрчлөн тогтоолгох- өргөдөл-6 , Банк солих-41, тэтгэмж-43, ажилгүйдлын тэтгэмж-7 , малчнаар ажилласан жилээ тогтоолгох -2 нийт 124 өргөдлийг хүлээн авч бүрэн шийдвэрлэж. 752 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

Тэтгэвэр, тэтгэмжийг тогтоож, олгох ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулж НДаатгалын санд 558489.6 мян төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлж, тэтгэврийн санд 1719000.0 мян төгрөгний санхүүжилт, тэтгэмж дээр 0,0 мян төгрөгний санхүүжилт авснаар

- Тэтгэвэрт - 477 тэтгэвэр авагчдад 2267315,4 мян төгрөгний тэтгэвэр,
- ХЧТА тэтгэмжинд- 21 даатгуулагчдад 2426,6 мянган төгрөг,
- Оршуулгын тэтгэмжинд- 9 тэтгэвэр авагчдад 9000,0 мян төгрөг,
- Жирэмсэн амаржсаны тэтгэмжийг- 14 даатгуулагчдад 24826,5 мян төг,

нийт 2303568,5 мян төгрөгний тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр олгоод олголтын зөрчилгүй ажиллаж байна. Зарцуулагдаагүй сангийн үлдэгдлийг НДХэлтсийн ЭМДаатгалын санд- 89957,6 мян, ҮОШМӨ санд- 21488,1 мян, Ажилгүйдлын санд - 5739,2 мян төгрөгийн шимтгэлийг 7 хоног бүр төвлөрүүлээд байна .

2022 оны Нэг бүртгэл-Нэг хяналтын жил ”-ийн хүрээнд хийх ажлын дэд төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулснаар:

- үйлчлүүлсэн иргэдийн бүртгэх,
- анхан шатны бүртгэл хөтлөх
- өргөдлийн бүртгэл зэргийг хөтлөсөн.

Жилийн хугацаанд 752 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж, зөвлөгөө өгөн ажиллаа.

Нийгмийн даатгалд хамраг-даагүй “Мөнххуранхаан” ХХК-ийг шинээр нийгмийн даатгалд хамруулан 1170,0мян төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлэн авлаа.

Эрдэнэцагаан сумын 83053616,48 төгрөгийг шимтгэл данс андуурч орсон учир залруулгын гүйлгээ хийсэн

2021 оны харилцахын-4, тооцооны хуудас тайлан-2, хөнгөлөлт чөлөөлөлтийн тайлан-1,малчны зөвлөлийн тогтоол баримтууд -1 зогсоогдсон 27 тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.

Мал эмнэлгийн чиглэлээр:

2022 оны 10 сарын 22, 23-ны өдрүүдэд Сүхбаатар аймагт сумын Засаг даргын тамгын газрын төрийн сангийн дарга, ХАА-н тасгийн мэргэжилтэн, нийгмийн халамжийн байцаагч нарын хамт НҮБ-ын Европын холбооны санхүүжилттэй төслийн хүрээнд зохион байгуулагдсан “Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүй” сэдэвт 2 өдрийн сургалтанд хамрагдсан. Сургалт цаг үеийн шаардлагад нийцсэн маш үр дүнтэй болсон.

2022 оны 10 дугаар сарын 24,25-нд аймгийн Засаг дарга М.Идэрбатаар ахлуулсан ажлын хэсэг тус суманд ирж ажилласан бөгөөд уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн Мал эмнэлгийн газрын дарга М.Молорчимэг ирж ажиллан мал эмнэлгийн тасгийн ажилтай танилцан ажил төрлийн холбогдолтой үүрэг чиглэл өгч, мал эмнэлгийн тасгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна гэж дүгнэсэн. Мөн хувийн мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн эмч нар багийн Засаг дарга нартай тусгайлан уулзаж МАЭМ-ийн тухай хуулийн талаар танилцуулж, уг хуулийг хэрэгжүүлэх тэдгээрийн ажлын уялдаа холбоог сайжруулах тал анхаарч ажиллах шаардлага тавьсан..

Малын амьтны зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ болох бруцеллёзын вакцинжуулалтын ажлыг 4 группээр зохион байгуулж, тарилгын ажлын явцад хяналт тавин ажиллсан бөгөөд тарилгад сумын хэмжээнд 305 өрхийн 4454 охин тугал, 442939 охин хурга, 20393 охин ишиг нийт 67786 охин төл хамрагдаж, тарилгын ажил 100%-тай хангагдсан.

2022-10-04-нд малын эмч И.Эрдэнэдалайгаас ирсэн өөрийн багаас Мөнххаан, Түвшинширээ сумдуудтай хиллэдэг захын айл өрхүүдэд малын гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарих хүсэлтийг уламжлан, аймгийн Мал эмнэлгийн газарт албан тоот хүргүүлсэн.

2022-10-20-нд хуралдсан сумын ИТХ-ын зөвлөлийн хуралд “Малын эрүүл мэнд дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн талаар мэдээлэл тавьсан.

Аймгийн Засаг даргын 2022 оны 10 сарын 11-ний өдрийн А/522 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын Засаг даргын 2022 оны 10 сарын 18-ны өдрийн А/125 дугаар Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг зохион байгуулах тухай захирамж гарган тарилгын ажлыг 4 группээр зохион байгуулсан бөгөөд тарилгын ажилд шаардагдах бензин шатахууны үнэ 1484000 төгрөгийг шийдвэрлүүлсэн. Одоогоор 32 өрхийн 1826-үхэр, 752-тугал нийт-2578 үхэр хамрагдаж, тарилга 11,8% байна.

Тарилгын ажлын явц, тарилга хийх технологид байнга хяналт тавин ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд аймагт 1 удаагийн сургалтанд хамрагдаж, 1 хариутай бичгийг барагдуулж, аймгийн мал эмнэлгийн газарт бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин болон орон нутгийн вакцин тарилгын материалыг нэгтгэлийг хянаж дүгнэн хүргүүлсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн чиглэлээр:

- Олон улсын "ЭКО" хөтөлбөрт хамрагдаж, ногоон орчин бүрдүүлэх зорилгоор 1-5, 6-9 ~р анги 2 ангиллаар "Цэцгийн баяр-Бидний баяр" -ыг зохион байгуулав. Цэцгийн баяраар 333 цэцэг нэмэгдэж, сургуулийн хэмжээнд нийт 520 цэцэгтэй боллоо. ТОП -10 цэцгээс 9 төрлийн 47 ш, навчаараа гоёдог 198ш, цэцгээрээ гоёдог 119ш, ховор-21ш, гоёмсог-24ш цэцэгтэй боллоо. Цэцгийн тоо, төрөл өнгө үзэмж ургалтаар
1-5-р ангиудаас:
1-р байр Д.Мөнхжаргал багштай 5а анги
2-р байр Э.Шинэтуяа багштай 2а анги
3-р байр Д.Мөнхгэрэл багштай 3а анги
Гоёмсог цэцэг номинацад Д.Мөнхжаргал багшийн ургуулсан "Гундаахай", Ховор цэцэг номинацад Э.Түмэнжаргал багшийн ургуулсан "Хим" цэцэг
6-9-р ангиудаас:
1-р байр Ц.Алтантүлхүүр багштай 7б анги
2-р байр П.Урантуяа багштай 7а анги
3-р байр Л.Мөнхтуяа багштай 8а анги
Гоёмсог цэцэг номинацад Д.Сарантуяа багшийн ургуулсан "Мөнгөний мод"

Ховор цэцэг номинацад Ц.Алтантүлхүүр багшийн тарьсан "Алтан загас" цэцэг тус тус шалгарлаа.

- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас зохион байгуулсан “Тогтвортой хөгжилд ЭКО клубын оролцоо” төслийн уралдаанд “Орчноо ногооруулъя” төсөл бичиж шалгаран ТЭРГҮҮН байр эзэлж 6 сая төгрөгийн санхүүжилттэй төслийг амжилттай хэрэгжүүлж байна.
- ЕБС-ийн ЭКО клубын зүгээс Тогтвортой хөгжлийн 17 зорилтын хүрээнд Хог хаягдлыг ангилан ялгах зорилготой "Хог хаягдлаа ангилж хэвшицгээе" гарын доорх материал ашиглан хогийн сав хийх уралдаанд ангиуд идэвхтэй оролцож, бага ангиудаас Ж.Мөнх-Од багштай 26 анги, дунд ангиудаас Д.Сарантуяа багштай 9а анги тус тус Тэргүүн байрт шалгарлаа.
- Сүхбаатар аймаг ХХААГ, Эрүүл мэндийн газар, МХГазар, Боловсрол, шинжлэх ухааны газар, стандарт, хэмжил зүйн газар, Монголын тогоочдын холбоо, Түмэнцогт сумын ЗДТГазар хамтран 2022.10.22-23 ны өдрүүдэд "Бүсийн тогооч, зөөгчийн сургалт ур чадварын уралдаан-2022" арга хэмжээнд тогооч Б.Цэвээнсүрэн, М.Буямаа, Д.Бүрэнцэцэг, Г.Ганчимэг нар амжилттай оролцож, сургууль, цэцэрлэгийн хоол, эмнэлэг эмчилгээний хоол, ресторан зоогийн газрын хоол, орон нутгийн брэнд хоол, орчин цагийн монгол хоол, нарийн боов үйлдвэрлэл, зөөгч, мөн спорт, урлагаар ур чадвараа сорьсноос сургуулийн үдийн цайны тогооч Б.Цэвээнсүрэн “ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛ ЗООГ” төрөлд дэд байр эзэлж мөнгөн медалиар шагнагдлаа.
- ҮЕ ТЭНГИЙНХНИЙ ДЭЭРЭЛХЭЛТ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ САРЫН аяны хүрээнд “Ялгаатай байдлыг ойлгож харилцъя”, “Бид дээрэлхэхгүй” чэллэнжид сургууль анги хамт олноороо нэгдлээ.
- Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр"-ийн хүрээнд аймгийн Онцгой байдлын газраас “ ИРГЭД ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ ЭРТ СЭРЭМЖЛҮҮЛЭГ”, “ЭССЭ” бичлэгийн уралдааныг Сүхбаатар аймгийн 13 сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан уралдаанд 9Б ангийн сурагч Н.Биндэр идэвхтэй оролцож 2-р байр эзлэв.
- БШУЯ, БЕГ, Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбооноос 10 дугаар сарын 17-18 өдрүүдэд зохион байгуулагдсан "Үе тэнгийнхний дээрэлхэлт, ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга зүй" сургалтад 600 гаруй нийгмийн ажилтан, сэтгэл зүйчээс нийгмийн ажилтан Т.Вера сонгогдон сургалтанд хамрагдав. Сургалтаар сургуулийн орчин нийгэмд тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг зааж сургасан байна.
- "НЭГДҮГЭЭРТ_ХҮҮХЭД" Сүхбаатар аймгийн ХҮҮХДИЙН VII чуулганд сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга, сургуулийн нийгмийн ажилтан, суралцагчдын төлөөлөл 5 суралцагчийн хамт оролцлоо. Оролцогч хүүхдүүд мэндчилгээ дэвшүүлж, сумын онцлог болон тэдэнд тулгамдаж буй асуудлаар 3 минутын видео бичлэг, урлагийн номер бэлтгэн үзүүллээ. Мөн Сүхбаатар аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлд сумаа төлөөлж 7б ангийн суралцагч Н.Есүй сонгогдов. Н.Есүй маань чуулганд оролцогч хүүхдүүдийг төлөөлөн телевизэд ярилцлага өглөө. 2022.10.13
- Аймгийн “Сүхбаатарын өнгө” сонины 5 жилийн ойг тохиолдуулан “Найргийн орны найрагч хүүхдүүд” уран уншлагын уралдааны нэгдүгээр шатыг Соёлын төвтэй хамтран зохимон байгуулахад нийт 23 сурагч оролцож, хоёр шатны уралдаанд бага, дунд насны ангилалд тус бүр 3 сурагч оролцсон.

- 96 ангийн багш Д.Сарантуяа “Өгөөмж” дэлгүүрийн эзэг О.Мөнхбаяртай хамтран сурагчдын дунд “Ирээдүйнхээ төлөө хуримтлуулцгаая” сэдвийн хүрээнд сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 21 сурагч хамрагдав.
- “Сүхбаатар-Нэг мөрөөдөл” ТББ –аас зохион байгуулагдсан уралдаанд МХУЗ-ын багш Л.Мөнхтуяа амжилттай оролцож “Шилдэг багш”-аар шалгарч 3 сая төгрөгийн эзэн болов

Хүүхдийн цэцэрлэгийн чиглэлээр:

- Монголын багш нарын баярын өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Баярын үеэр багшийн тангарагийг өргөсөн мөн өмнөх хичээлийн жилд амжилт гаргасан багш нарыг шагнаж урамшууллаа.
- Боловсролын мэдээллийн системд нийт 231 хүүхдийн бүх мэдээллийг бүрэн оруулж ямар ч алдаагүй шивэгдлээ.
- Аймгийн БШУГ-аас зохион байгуулсан “Хүүхэд төвтэй сургалтын арга зүй” сургалтад эрхлэгч 5 бүлгийн багш, хөгжмийн багш, хувилбарт сургалтын багш нар нийт 8 хүн хамрагдлаа.
- Мөн МУБИС-СӨБС-өөс зохион байгуулсан “Туслах багш нарыг чадавхжуулах” сургалтад 5 багш хамрагдлаа.
- 11 сард СӨБ-ын багш нараас “Гүйцэтгэлийн үнэлгээний шалгалтад” хамрагдах тул бүх багш нарын суурь мэдээллийн санг бүрдүүлэх ажил хийгдэж байна. Дээрх суурь судалгаа муу хийгдвэл тухайн багш шалгалтад орох боломжгүй тул сайтар хийх шаардлагатай юм.
- Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны 5-н жилийн тэтгэмжээ авсан багш нар маань байгууллагынхаа гадна хаяг логог монгол бичгээр бичүүлсэн гэрлэн хаягыг хийлгэлээ.
- Түмэнцогт суманд зохион байгуулагдсан Тогооч нарын тэмцээн, сургалтад манай 2 тогооч хамрагдан ба “хүүхдийн хоолны төрөл”-д амжилттай оролцсон.
- Шинээр 2 ажлын байрын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж шалгалтад өндөр оноо авч тэнцсэн хүнийг ажлын байраар хангалаа. Няравын сонгон шалгаруулалтад 4 хүн, багшийн сонгон шалгаруулалтад 1 хүн оролцсон болно.

Соёлын төвийн чиглэлээр:

- “Дуэт Дуэль” нээлттэй тэмцээн 2022 оны 9 сарын 2-ны өдөр зохион байгуулсан. Нийт 5 хос оролцож 153 үзэгч үзсэн.
- Ахмадын баяртай холбогдуулан сумын Ахмадын хорооноос 2022 оны 9 сарын 30-ны өдөр үзэсгэлэн зохион байгуулж, Ахмадын үзэсгэлэн, худалдаа, Баярын хурал, Баярын тоглолт, Үдшийн цэнгүүн гэсэн хөтөлбөртэй явагдлаа. Баярын хуралд 157 ахмад, Үдшийн цэнгүүнд 180 ахмад хамрагдаж ахмадын баярын үйл ажиллагаа сайхан болж өндөрлөсөн.
- Сүхбаатар аймгийн Уулбаян сумын харьяат Ардын жүжигчин Шарын Чимэдчэээ шавь нарын хамт 2022 оны 10 сарын 02нд тоглолтоо хийлээ. Тоглолтыг нийт 230 хүн үзэж өргөн дэлгэр сайхан тоглолт

боллоо. Соёлын төвийн хамт олон Ардын жүжигчиндээ хүндэтгэл үзүүлсэн.

- 2022 оны 10 сарын 05-ны өдөр Дэлхийн багш нарын баярын 51 дэхь өдөр, Монголын багш нарын баярын 28 дахь өдрийг тохиолдуулан Багш нарын баярын хурал, хүндэтгэлийн тоглолт, үдшийн цэнгүүн зохион байгуулсан. Нийт хүндэтгэлийн тоглолт-110, үдшийн цэнгүүнд-132 хүн хамрагдсан.
- Сумын манлай заан Т.Будын Алтан гадас одонгийн найранд хамтран ажиллаж. Үдшийн цэнгүүн зохион байгууллаа.
- 2022 оны 9 сарын 1 нээс эхлэн уламжлал болгон зохиогддог ахмадын болон нийтийн цэнгээнт бүжгийг зохион байгуулж байна.
- Орон нутагт кино үзвэр сэргээхээр кино тест үйл ажиллагаа г”**10-0-0 mini cinema**” кино театрт хамтран “киног 2022 оны 10 сарын 21 нд туршилтаар гаргасан. Энэхүү киног 60 гаруй хүүхэд үзсэн бөгөөд туршилт амжилттай болбол сумын иргэд дэлхийд нээлтээ хийж буй шинэ киног үзэх боломжтой болох ба хөдөө орон нутгийн хүүхдүүд кино театрт кино үзэх боломж хомс байдаг тул цаашдаа стандартын дагуу кино театрт кино үзэх боломж нээгдэнэ
- Аймгийн Засаг даргын хөрөнгө оруулалтаар хийгдсэн 10 сая төгрөгөөр байгууллагад шаардалагатай байгаа хөгжим, тенхик төхөөрөмж, хурлын ширээ, оффис ширээ сандал худалдан авлаа.
- Номын сангийн фондын баяжилтанд ЗДТГ-ын хууль эрх зүйн мэргэжилтэн Л.Дашбалжинням 20 ширхэг хууль, эрх зүйн ном хандивлалаа.
- Соёлын сайдын 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/212 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын хүрээнд нийтийн номын сан нь хүүхдэд зориулсан 41 нэрийн 55 ширхэг номоор сан хөмрөгийн баяжилт хийгдлээ.
- Сүхбаатарын өнгө сонины 5 жилийн ойн арга хэмжээний хүрээнд явагдаж буй “**Найргийн орны найраг хүүхдүүд**” сэдэвт уншлагын уралдааны 1-р шатны шалгаруулалтыг ЕБС-ийн номын сантай хамтран зохион байгууллаа. Соёлын биет өвийн улсын тооллого 2022 оны 9 сарын 28,29 ны өдрүүдэд Уулбаян суманд явагдлаа. Нийт 300 гаруй км 13 дурсгалт газарын 29 хөшөө дурсгалыг бүртгэж, баталгаажуулж авлаа.
- Бүжгийн дугуйлан 2022 оны 10 сарын 01-нээс эхлэн Бүжгийн багш А.Мөнгөнсүлд ЕБС-ийн сурагчдын дунд бүжгийн дугуйланг хичээллүүлж байна. Өдрийн 3 ээлжээр нийт 90 гаруй хүүхэд бүжгийн дугуйланд хамрагдаж байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

2022 оноос эхлэн дагаж мөрдөх нийт 22 хууль тогтоомжийн жагсаалтыг гарган, тамгын газрын мэргэжилтэн, төсөвт байгууллагын дарга нарт танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллах талаар мэдээлэл хүргүүлсэн

Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулахаар судалгаа, шинжилгээ хийж, төслөөр боловсруулаад байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах хүрээнд төсөвт байгууллага, мэргэжилтэн бүртэй хамтран ажиллаж байна.

Байгууллагын даргын шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг бүрэн хангуулж захирамж-126, тушаал-4, албан тоот-10 нийт 130 шийдвэрийг боловсрууллаа.

Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг хууль тогтоомжийн хүрээнд ажлын байранд хориглох зүйлс, хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болох үндэслэл, төрийн албан хаагчийг шилжүүлэх, сэлгэх, зарчим, залилах, хулгайлах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл бэлтгэн цахим хэлбэрээр төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, мэргэжилтэн нарт хүргэсэн.